БАТЛАВ.
"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАЯРСАЙХАН

## "УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН 2019 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

2019 оны 06 дугаар сарын 24 Улаанбаатар хот

| № | Хийх ажлын агуулга | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах нэгж, албан тушаалтан | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | **Нэг. Хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх** | | | |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах | Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаар нийт ажилтнуудад мэдээлэл, танилцуулга хийх | 01, 09 дүгээр сарууд | Захиргаа удирдлагын хэлтэс, ЭБАТ | |
| 2 | | Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг хэвлэмэл материал тараах гэх мэт/ | Жилдээ | Захиргаа удирдлагын хэлтэс, ЭБАТ | |
| 3 | | Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг ажилтнуудад түгээж ажиллах | тухай бүр | ЭБАТ | |
| 4 | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон | Тухайн жилийн төсөв | 1 дүгээр сарын 10-ны дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 5 | | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл | 4 дүгээр сарын 25-ны дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 6 | | Улирлын төсвийн гүйцэтгэл | 4, 7, 10, 1 сарын 8-ны дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 7 | | Хагас жилийн төсвийн гүйцэтгэл | 8 дугаар сарын 15-ны дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 8 | | Дараа жилийн төсвийн төсөл | 9 дүгээр сарын 15-ны дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 9 | | Хагас жилийн санхүүгийн тайлан | 8 дугаар сарын 15-ны дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 10 | | Жилийн эцсийн санхүүгийн тайлан | 4 дүгээр сарын 25-ны дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 11 | | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт | 4 дүгээр сарын 25-ны дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 12 | | Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | 7 дугаар сарын 1-ний дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 13 | | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | улирал бүр | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 14 | | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15 | нийтэд тухай бүр мэдээлэх, цахим хуудсанд байршуулах | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт | өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 16 | | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт | өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 17 | | Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 18 | | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | батлагдсанаас хойш 7 хоногийн дотор | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 19 | | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах | Жилдээ | Санхүү, бүртгэлийн хэлтэс | |
| 20 | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах | Тухайн байгууллагаас олгож байгаа Техникийн нөхцлийн зөвшөөрлийн жагсаалт гаргах, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах | 3 сард | Хэрэглэгчтэй харилцах алба | |
| 21 | | Дулаан хангамжийн өнөөгийн байдал цаашдын зорилт тулгарч буй хүндрэлийн талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх болон цахим хуудсандаа ил тод байршуулах | Жилдээ | Хэрэглэгчтэй харилцах алба | |
| 22 | | Техникийн нөхцөл олголтын талаар байгууллагын цахим хуудас болон ил тод мэдээллийн самбарт байршуулах | тухай бүр | Хэрэглэгчтэй харилцах алба | |
| 23 | | Техникийн нөхцөл олгох гишүүдийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага болон мэргэжлийн байгууллагаас төлөөлөл оролцуулах | тухай бүр | Хэрэглэгчтэй харилцах алба | |
| 24 | | Аливаа үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор бусад байгууллагаас олгосон зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх г.м бусад үйл ажиллагаа эрхлэх/, түүний талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах | тухай бүр | Хэрэглэгчтэй харилцах алба | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 25 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах | Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гишүүд, Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер, Дэд захирал, Албадын дарга нар, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын танилцуулгыг цахим хуудсандаа шинэчлэн байршуулах | байнга | Захиргаа удирдлагын хэлтэс | |
| 26 | | Хэрэглэгчдэд үйлчлэх ажилтны хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа шинэчлэн байршуулж ажиллах | байнга | Захиргаа удирдлагын хэлтэс | |
| 27 | | Боловсон хүчнийг сонгон шалгаруулах журмыг боловсруулан батлуулж цахим хуудсандаа байршуулах | байнга | Захиргаа удирдлагын хэлтэс | |
| 28 | | Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчлэх/ | байнга | Захиргаа удирдлагын хэлтэс | |
| 29 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах | тухай бүр | Хангамж, худалдан авах ажиллагааны хэсэг | |
| 30 | | Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулах | тухай бүр | Хангамж, худалдан авах ажиллагааны хэсэг | |
| 31 | | Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулах | тухай бүр | Хангамж, худалдан авах ажиллагааны хэсэг | |
| 32 | | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах | тухай бүр | Хангамж, худалдан авах ажиллагааны хэсэг | |
| 33 | | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах | тухай бүр | Хангамж, худалдан авах ажиллагааны хэсэг | |
| 34 | | Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх | тухай бүр | Хангамж, худалдан авах ажиллагааны хэсэг | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 35 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах | жилдээ | Бүх алба, хэлтэс, нэгжийн дарга нар | |
| 36 | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх | Байгууллагын ёс зүйн зөвлөлийн шинэчлэн байгуулах | 3 сард | Захиргаа удирдлагын хэлтэс, | |
| 37 | | Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг батлуулах | 4 сард | Захиргаа удирдлагын хэлтэс, | |
| 38 | | Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас санал авах, саналыг тусгах | 4 сард | Захиргаа удирдлагын хэлтэс, | |
| 39 | | Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/ | 5 сард | Захиргаа удирдлагын хэлтэс, | |
| 40 | | Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх | тухай бүр | Захиргаа удирдлагын хэлтэс, | |
| 41 | | Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлж ажиллах | тухай бүр | Захиргаа удирдлагын хэлтэс | |
| 42 | Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах /төрийн болон байгууллагын нууцад хамаарахаас бусад/, цахим хуудсандаа байршуулах | Удирдлагын шийдвэр /Хувь нийлүүлэгчдийн Хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаал/-ийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/ | тухай бүр | ЗУХ, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | |
| 43 | | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, хууль тогтоомж /хуульчилсан акт/ | тухай бүр | ЗУХ | |
| 44 | | Үйлчлүүлэгчээс авч байгаа төлбөр хураамжийн талаарх мэдээллийг мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулсан байх | байнга | Хэрэглэгчтэй харилцах алба, Хэрэглэгчийн үйлчилгээний алба | |
| 45 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль | Засгийн газар, яамд, Төрийн өмчийн хорооны шийдвэр | тухай бүр | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 46 | тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах | Компанийн дүрэм, дотоодод мөрдөгдөх дүрэм, журам, заавар | тухай бүр | ЗУХ | |
| 47 | | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, хянан шалгах зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс, урамшууллын хэмжээ | тухай бүр | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | |
| 48 | | Ноогдол ашгийн хувь, хэмжээ, хувьцаа эзэмшигчдэд олгосон хуваарилалт | тухай бүр | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | |
| 49 | | Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээ /ТӨХ -той / | тухай бүр | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | |
| 50 | | Үйлчилгээг иргэдэд хүргэдэг хэвлэмэл материал, гарын авлага, зурагт хуудас зэргийг хэвлүүлэн бэлтгэж , үйлчилгээний зааланд байршуулах | байнга | Хэрэглэгчтэй харилцах алба | |
| 51 | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах | Төрийн үйлчилгээг шуурхай болгох зорилгоор байгуулсан нэг цэгийн үйлчилгээнд байнгын ажилтан ажиллуулж гаргасан санал гомдлыг чирэгдүүлэхгүй шуурхай барагдуулах арга хэмжээ авах | байнга | Хэрэглэгчтэй харилцах алба | |
| 52 | | Иргэд аж ахуйн нэгжийн өргөдөл санал хүсэлт мэдээллийг чирэгдүүлэхгүй хүлээн авах нөхцлийг бүрдүүлэн, хүлээн авч шуурхай барагдуулах. | байнга | Хэрэглэгчтэй харилцах алба | |
| 53 | | Халаалт болон халуун устай холбоотой гомдлыг шуурхай барагдуулах зорилгоор Нийслэлийн диспетчерийн төв болон ОСНААУГ-тай хамтран ажиллах. | байнга | Хэрэглэгчтэй харилцах алба | |
| 54 | | Өнгөрсөн онд халаалтын хүндрэлтэй гомдолтой өвөлжсөн иргэн аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гарган дүгнэж ОСНААУГ-тай хамтарсан ажлын төлөвлөгөө батлуулан төлөвлөгөөний дагуу хамтарч ажиллах. Төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах. | 2,3 дугаар улиралд | Хэрэглэгчтэй харилцах алба, Хэрэглэгчийн үйлчилгээний алба | |
| 55 | | Иргэд хэрэглэгчдийн санал хүсэлт, мэдээллийг 70047005 дугаарын утсаар мэдээлэл хүлээн авч хурдан шуурхай барагдуулах. | байнга | Хэрэглэгчтэй харилцах алба | |
| 56 | | Өргөдөл албан хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар цахим хуудсаар мэдээллэх | байнга | Хэрэглэгчтэй харилцах алба | |
| 57 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах | Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлан гаргах | 2 сард | ЭБАТ | |
| 58 | | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ | тухай бүр | ЭБАТ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 59 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх | АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ | тухай бүр | ЭБАТ | |
| 60 | | АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ | тухай бүр | ЭБАТ | |
| 61 | | АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт | тухай бүр | ЭБАТ | |
| 62 | | Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох | тухай бүр | ЭБАТ | |
| **Хоёр. Авлигатай тэмцэх санал, санаачилга** | | | | | |
| 63 | Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлах | 2 сард | Гүйцэтгэх захирал | |
| 64 | | Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг цаг, хугацаандаа хэрэгжүүлэх | төлөвлөгөөний дагуу | Нийт алба, хэлтэс, нэгжийн дарга нар | |
| 65 | | Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаанд ТӨБЗГазарт хүргүүлэх | 12 сард | ЭБАТ | |
| 66 | | Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх | 12 сард | ЭБАТ | |
| 67 | Байгууллагын удирдлагууд авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлттай байх | Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан төсөв хөренгийг төлөвлөх | 1-р сард | ЭБАТ | |
| 68 | | Байгууллагын ubds.energy.mn цахим хуудсыг нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой болгохоос гадна хэрэглэгчдэд үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор Dulaan.mn онлайн хуудсыг хэрэглэгчдэд сурталчлан байнга ажилагаатай байлгах | 4 сард | Хэрэглэгчтэй харилцах алба | |
| 69 | | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдэх ажиллагааг зохион байгуулах | жилдээ | ЭБАТ | |
| 70 | | Удирдах албан тушаалтнууд авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт, санаачилгатай байж ажилтнуудад үлгэр жишээ байдал үзүүлэх | байнга | Нийт алба, хэлтэс, нэгжийн дарга нар | |
| 71 | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх | Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах | 4, 10 сард | Захиргаа удирдлагын хэлтэс, Ёс зүйн зөвлөл | |
| 72 | | Албадын харилцааны журмыг боловсронгуй болгон шинэчлэн батлуулах мөрдүүлэх | 3,4 сард | Техникийн бодлогын хэлтэс | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 73 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих | байнга | Ёс зүйн зөвлөл | |
| 74 | | Ашиг сонирхолын зөрчил, авилгын эсрэг ажиллагааны төлөвлөгөө, тайлан мэдээг удирдах дээд байгууллагад хүргүүлэх | тухай бүр | ЭБАТ | |
| 75 | Дотоод хяналт шалгалт | Дотооддоо хяналт шалгалт хийх журмын дагуу ажиллах | 5-6 сард | Аюулгүй ажиллагаа, хяналт, мониторингийн хэлтэс | |
| 76 | | Хяналт шалгалтын мэдээллийг ил тод мэдээллийн самбараар мэдээллэх, зөрчлийг арилгуулах, зөрчлийн мөрөөр /зөвлөмж шаардлага хүргүүлэх, сургалт явуулах, хамт олонд мэдээллэх гэх мэт/ арга хэмжээ тооцох | тухай бүр | | |
| 77 | | Хэрэглэгч байгууллага, иргэдээс ирсэн санал хүсэлт гомдол хугацаандаа шийдвэрлэгдэж байгаа эсэх талаар хяналт тавьж хугацаа хэтрүүлсэн буюу шийдвэрлээгүй үед хариуцлага тооцож ажиллах | байнга | | |
| 78 | | Техникийн нөхцөл олгосон хэрэглэгчдээс техникийн нөхцөл олгох явцад хүндрэл, хүнд суртал, ашиг сонирхлын зөрчил байсан эсэх талаар баталгаа гаргуулах | тухай бүр | Аюулгүй ажиллагаа, хяналт, мониторингийн хэлтэс | |
| 79 | | Шинээр дулаанд холбогдсон хэрэглэгчдээс дулаан хангамжийн үйлчилгээний талаар санал асуулга авах, санал асуулгын дүнгээр ажил зохион байгуулах | 10 сард | | |
| 80 | | Аж ахуйн гэрээ хийж байгаа хэрэглэгчдээс санал хүсэлтийн дэвтрээр байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, аж ахуйн гэрээтэй холбоотой асуудлаар санал хүсэлтийг авч, зөрчил гарсан тохиолдолд арилгуулах арга хэмжээ авах | 10 сард | Аюулгүй ажиллагаа, хяналт, мониторингийн хэлтэс | |
| 81 | Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар АТГ-т мэдээллэх | | тухай бүр | Нийт ажилтнууд | |

ХЯНАСАН: ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.БАТМӨНХ

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН: ЭБАТ Л. Болормаа Л.БОЛОРМАА